

Эхэд тулгуурлан багц даалгаврууд гүйцэтгэх тул доош гүйлгэн бүх даалгаврыг ажиллана уу!

Сухомлинскийн хүүдээ бичсэн захидал

Өдрийн мэнд. Хайрт хүү минь.

Ингээд чи үүрнээсээ нислээ. Том хотод амьдарч, их сургуульд сурч бие даасан хүн гэдгээ мэдрэхийг хүсэж байгаа. Энэ шинэ, буцалсан амьдралд ороод чи аав, ээж хоёрыгоо, төрсөн гэрээ санах нь багасна гэдгийг аав нь туршлагаасаа мэдэж байна. Ээж, бид хоёрыгоо бараг л санахгүй дээ. Энэ бүхэн чи минь амьдралыг таньж мэдсэний дараа хэзээ боловч тохиолдох л болно... Эцэг эхийнхээ үүрнээс нисэж байгаа хүүдээ бичиж суугаа анхны захидал минь энэ. Энэ захидлыг минь насан туршдаа хадгалж, дахин дахин уншиж, сургаалыг минь санаж яваасай гэж хүсэж байна, хүү минь.

Төрсөн гэрээсээ явахдаа би 15 настай байлаа. Кременчугскийн багшийн их сургуульд элссэн үе минь тэр. 1934 он хүнд жил байж билээ. Төгсөлтийн шалгалт ямар байсныг сайн санадаг юм. Шалгалтаа сайн өглөө. Ингэж миний хичээл эхэлсэн юм. Ходоод хоосон байхад эрдэм сурна гэдэг хэцүү, их хэцүү байж билээ. Гэвч шинэ ургацын талх нэг л өдөр идсэн юм. Ээж минь надад шинэхэн ургацын талх явуулсан тэр өдрийг хэзээ ч мартдаггүй юм. Матвей өвөөгөөр ирсэн ээжийн минь анхны илгээмж тэр байлаа. Зөөлхөн, шинэхэн, тансаг үнэр нь ханхалсан талх байсан юм. Бас миний насан туршдаа хадгалж байгаа гэж ярьж байгаа аавын минь анхны захидал ирсэн байв. Аавын минь “Энэ талхыг бүү мартаарай хүү минь. Би бурханд итгэдэггүй ч энэ талхыг ариун гэдгийг хэлэх байна. Чи хаанаас ниссэн гэдгээ санаж яваарай, хүү минь” гэсэн байж билээ. Хүү минь үүнийг бүү мартаарай. Чиний өвөө, миний аав Омелько Сухомлин тариачин байсан юм. Анжсаа барьж яваад л амьсгал хураасан даа. Угсаа гарлаа хэзээ ч мартаж болохгүй шүү. “Чи сурч боловсорч байгаа ч энэ талхыг хийх гэж хэн нэгэн хөдөлмөрлөж байгааг санаарай. Чи сургуулиа төгсөж, багш боллоо ч энэ талхыг мартаузай. Талх бол хүний хүч хөдөлмөр, ирээдүйн итгэл найдвар, чиний болон хүүхдүүдийн чинь амьдрал юм шүү” гэж аав минь анхны захидалдаа бичсэн байж билээ.

Би энэ ертөнц дээр бараг тавин жил амьдарч байна. Хөдөлмөр гэж юу болохыг чамаас илүүгээр мэднэ хүү минь. Чамайг анхныхаа амралтаар ирэхэд чинь аж ахуйн ажилтан хөрштэйгөө танилцуулна аа. Тэр алим ургуулдаг юм. Тэр үүнийгээ ямар гайхалтай хийдэг гээч. Өнөөдөр бүх хүн тийм байсан бол энэ нийгэм ч өөр байх байлаа...Эрүүл энх, аз жаргал, хамгийн сайн сайхныг хүсье. Ээж болон дүү чинь чамд мэнд хүргэж байна. Тэд өчигдөр чамд захидал биччихсэн юм.

Үнсье хүү минь. Аав нь.

Монгол хэлний даалгаврууд

1. Захидлын бүтцийг агуулгатай нь зөв харгалзуулаарай.

- | | |
|------------|---------------------------------|
| 1. Эхлэл | A. Аавынхаа тухай дурссан |
| 2. Гол | B. Хүүдээ сургамжилсан өнгө аяс |
| 3. Төгсгөл | C. Хөдөлмөрийн үнэ цэний тухай |

- A. 1B, 2C, 3A
B. 1B, 2A, 3C
C. 1C, 2B, 3A
D. 1C, 2A, 3B

2. Аав яагаад хүүдээ захидал бичих болсон бэ?

- A. Хөршөө танилцуулах гэж
B. Багшийн сургуульд орсон гэдгээ хэлэх гэж
C. Хүүдээ талх өгөх гэж
D. Хүүдээ захиас хэлэх гэж

3. Захидлыг хэддүгээр биеэс хэддүгээр биед хандан бичсэн бэ?

- A. 1-р биеэс 3-р биед
B. 2-р биеэс 3-р биед
C. 1-р биеэс 2-р биед
D. 3-р биеэс 2-р биед

4. Захидлын тодруулсан хэсэгт илэрч буй бичигчийн санаанд тохирох хариуг сонгоорой.
- A. Танин мэдүүлэх
 - B. Ятган итгүүлэх
 - C. Цэнгээн хөгжөөх
 - D. Сануулан захирах
5. Хүүгийн өвөө аавд нь яагаад талх явуулсан бэ?
- A. “Хаанаас эхэлснээ санаж яваарай” гэж ойлгуулах гэж
 - B. Хүүгээ өлсгөхгүйн тулд
 - C. Хөрш нь хөдөлмөрч хүн учраас
 - D. “Энэ захидлыг хадгалж яваарай” гэж хүүдээ хэлэх гэж
6. Хүүдээ захиж, сургасан өнгө аястай өгүүлбэрийг олоорой.
- A. Ээж болон дүү чинь чамд мэнд хүргэж байна
 - B. Би ч бас аавынхаа надад бичсэн анхны захидлыг нь хадгалдаг.
 - C. Матвей өвөөгөөр ирсэн ээжийн минь анхны илгээмж тэр байлаа.
 - D. Гэхдээ хүү минь, аавын минь зөв байж, ээж минь үнэн хэлжээ гэж бодох цаг ирдэг юм.
7. “Шалгалтaa сайн өглөө” гэсэн өгүүлбэрийн тодруулсан “-аа” бүтээврийн утгыг зөв тодорхойлсон хариуг олоорой.
- A. Заахын тийн ялгалын нөхцөл
 - B. I биед хамаатуулах нөхцөл
 - C. Эзэнд хамаатуулах нөхцөл
 - D. II биед хамаатуулах нөхцөл
8. “Чи сургуулиа төгсөж, багш боллоо ч энэ талхыг мартуузай” өгүүлбэрийн онцолсон бүтээврийг зөв тодорхойлсон хэсгийг олоорой.
- A. Даалган захирах
 - B. Сануулан захирах
 - C. Тушаан захирах
 - D. Зөвшөөрч захирах
9. “Би энэ ертөнц дээр бараг тавин жил амьдарч байна.” өгүүлбэрийн цөм бүтцийг зөв тодорхойлсныг олоорой.
- A. Би амьдарч байна.
 - B. Би тавин жил амьдарч байна.
 - C. Амьдарч байна.
 - D. Би жил амьдарч байна.
10. Сухомлинскийн аавын бичсэн гол санааг илэрхийлэх өгүүлбэр аль нь вэ?
- A. Захидлыг минь насан туршдаа хадгалаарай.
 - B. Угсаа гарлаа хэзээ ч мартаж болохгүй шүү.
 - C. Өнөөдөр бүх хүн тийм байсан бол энэ нийгэм ч өөр байх байлаа...
 - D. Энэ талхыг бүү мартаарай хүү минь.

Уран зохиолын даалгаврууд

11. П.Бадарчийн “Есөн эрдэнийн орон” шүлгийн

“Улсынхаа заяаг түшиж хувьсгалч ах нарын

Уухайлан мандуулсан туг шүр адил улаан билээ” хэмээх тодруулсан хэсэгт юуг юутай, ямар шинжээр нь адилтган бичсэн байна вэ?

- A. Шүр эрдэнийг тугтай шинж чанараар нь адилтгасан
- B. Шүр эрдэнийг тугтай улаан өнгөөр нь адилтгасан
- C. Тугийг шүр эрдэнэтэй улаан өнгөөр нь адилтгасан
- D. Тугийг шүр эрдэнэтэй шинж чанараар нь адилтгасан

12. Л.Түдэв “Зурагтай танилцсан түүх” туужийн доорх хэсгийг уншаад, монгол үндэстний соёлын ямар зүйлс илэрч байгааг зөв олоорой.

“... Цорын ганц боломжийн мод гэвэл өрөм хатаадаг тос нэвчсэн бор мод эргүүл дээр байв. Хэсэг эргэлзсэний эцэст би тэр модыг олзлон авч, тулганы захаас аргалын цагаан үнс хайж олоод дээр нь нунтаглан түрхэв.”

- A. өрөм хатаадаг мод, эргүүл, тулга, аргал
- B. эргүүл, тулга, мод, аргал, тос, өрөм
- C. эргүүл, үнс, цор ганц, цагаан, тос
- D. өрөм хатаадаг мод, ганц, эргүүл, тулга

13. Ч.Лодойдамбын “Шаргачин” өгүүллэгт “эх үр хоёр гашуун зовлонд учралгүй өнгөрч болох байсан” гэж үзвэл түний шалтгаан нь юу байна вэ?

- A. Аялагчидтай таараагүй бол
- B. Машин хурдаа нэмээгүй бол
- C. Янзага халуун наранд нозоорч унтаагүй бол
- D. Жолоочийн хажуугийн хүн тамхи татах гээгүй бол

14. Хөндийд тор тавьж шаргачин барьж буй үйл явдал ямар зохиолд гардаг вэ?

- A. Шаргачин
- B. Шидэт бийр
- C. Ас-Синдбаб хааны үлгэр
- D. Тосгоны овгор

15. Д.Данзанравжаагийн “Гурван сүлжээ сургаал” шүлгийн сургаалд “Аливаа шинжээс эрхэм хэмээн юу юуг хэлсэн бэ?

- A. Билиг, ухаан, чадал
- B. Бие, хэл, сэтгэл
- C. Мэргэн, түргэн, даамай
- D. Аав, ээж, эх орон

Үндэсний бичгийн даалгаврууд

16. холбоо үгийг уншаарай.



- A. Уух хэлбэр
- B. Одох хялбар
- C. Утга хялбар
- D. Утга хэлбэр




17. “Хабур-ун уларил-ду ирэбэ.” өгүүлбэрийг зөв хөрвүүлснийг олоорой.



18. Шар (үхэр) үгийг зөв бичсэнийг олоорой.



19. “ᠠᠨᠢᠨᠠᠨ” гэдэг үгэнд тохирох олон тооны дагаврыг олоорой.



20. “ᠬᠠᠭᠠᠨᠠᠨᠠᠨ” цэгийн оронд эзэнд хамаатуулах нөхцөлийн тохирохыг сонгоорой.

